



V/2022


Тархаасан: 2022 оны 6 дугаар сарын 13



Үнэмлэхүй их температур 2022 оны 5 дугаар сард Өмнөговь аймгийн Мандал-Овоо суманд 35.0 °C-д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2022 оны 5 дугаар сард Өмнөговь аймгийн Мандал-Овоо суманд 35.0°C, үнэмлэхүй бага температур Баянхонгор аймгийн Гурванбулаг суманд -16.0°C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар



¹ - Сүүлийн 30 жил

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2022 оны 5 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Булган аймгийн Тэшиг суманд 39.3 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Өвөрхангай аймгийн Төгрөг суманд 30 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар


Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2022 оны 5 дугаар сард Тахилт орчимд 0.124 мг/м³-д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас 0.074 мг/м³-ээр буюу 2.5 дахин давсан байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2022 оны 5 дугаар сард Зурагт, 13 дугаар хороолол, Тахилт, Баруун дөрвөн зам орчимд 0.058 мг/м³-0.081 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.008 мг/м³-0.031 мг/м³-ээр буюу 16.0-62.0 хувиар давсан байна.

Харин РМ 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2022 оны 5 дугаар сард Баруун дөрвөн зам, Ургах наран хороолол, Хайлааст, Мишээл экспо төв, 13 дугаар хороолол, Тахилт, Цахилгаан станц, Баянхошуу орчимд 0.103 мг/м³-0.231 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.003 мг/м³-0.131мг/м³-ээр буюу 3.0 хувиас 2.3 дахин давсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь РМ 10 тоосонцрын дундаж агууламж 2022 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.020 мг/м³ (36.5%)-ээр, азотын давхар ислийн дундаж агууламж 0.008 мг/м³ (33.8%)-ээр их, харин хүхэрлэг хийн дундаж агууламж 0.002 мг/м³ (9.2%)-ээр, РМ 2.5 тоосонцрын дундаж агууламж 0.002 мг/м³ (12.8%)-ээр тус тус бага байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, мг/м³



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны эхний 5 сарын байдлаар 1948 болж, өмнөх оны мөн үеэс 186 (10.6%) -гаар өссөн байна. Газар хөдлөлт 2022 оны эхний 5 сарын байдлаар 29 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 208 (87.8%) -аар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 5 сарын байдлаар нийт 58 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн 36 (38.3%) -гаар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 5 сарын байдлаар 8.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, 2.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-V	2020 I-V	2021 I-V	2022 I-V	2022 I-V
					2021 I-V
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	2 690	2 306	1 762	1 948	110.6
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	20	32	237	29	12.2
Объектын түймрийн тоо	2 275	1 703	1214	1 538	126.7
Амь насаа алдсан хүний тоо	66	73	94	58	61.7
Учирсан хохирол, тэрбум төгрөг	5.5	104.3	9.8	8.2	83.7
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	1 012.9	167.5	962.2	2 096.3	2.2 ¹

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр:

Цаг уур, орчны шинжилгээний газар;
Онцгой байдлын ерөнхий газар;

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 7 дугаар сарын 19

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212